



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/93/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2020 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа

Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 43

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН
ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Б.БАТСҮХ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний, өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>794,197,954.51</u>	<u>1,302,277,506.74</u>
33	АВЛАГА	23,814,000.00	69,287,272.02
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		45,380,343.02
33300	Татаас, санхүүжилтийн авлага	23,814,000.00	23,906,929.00
35	БАРАА МАТЕРИАЛ	770,383,954.51	1,233,083,163.72
351	Түүхий эд материал	763,796,704.61	1,206,339,290.43
35110	Тусгай зориулалттай материал	758,012,197.15	912,945,934.12
35130	Эм боох материал	5,784,507.46	293,393,356.31
354	Хангамжийн материал	6,587,249.90	26,743,873.29
35410	Бичиг хэргийн материал		3,351,800.00
35440	Түлш, шатах тослох материал	4,218,999.90	10,554,414.29
35450	Барилгын засварын материал		3,994,300.00
35460	Хүнсний материал	80,000.00	287,109.00
35470	Бусад хангамжийн материал	2,288,250.00	8,556,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,277,962,546.54</u>	<u>30,259,065,102.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,277,962,546.54	30,259,065,102.99
392	Биет хөрөнгө	23,414,242,540.08	27,395,345,102.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	20,093,638,636.53	25,083,579,303.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	791,351,692.01	1,708,650,852.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	552,474,338.00	628,274,338.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	416,464,449.14	463,174,431.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,846,780,536.76	9,239,874,836.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	5,178,890,614.60	5,644,059,571.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	450,132,856.83	387,456,049.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	311,018,870.19	255,634,288.87
39214	Бусад үндсэн хөрөнгө	210,091,146.00	210,091,146.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	41,149,348.10	82,411,427.17
393	Биет бус хөрөнгө	2,863,720,006.46	2,863,720,000.00
39301	Програм хангамж	9,883,087.00	9,883,087.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	9,883,080.54	9,883,087.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,863,720,000.00	2,863,720,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>27,072,160,501.05</u>	<u>31,561,342,609.73</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>92,929.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	92,929.00
413	Өглөг	-	92,929.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		92,929.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>27,072,160,501.05</u>	<u>31,561,249,680.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	27,072,160,501.05	31,561,249,680.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,297,152,047.96	10,297,152,047.96
51101	Өмч: - төрийн	10,297,152,047.96	10,297,152,047.96

512	Хуримтлагдсан үр дүн	(3,126,836,103.37)	1,362,346,005.31
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,506,644,919.06)	(3,126,836,103.37)
51220	Тайлант үеийн үр дүн	(620,191,184.31)	4,489,182,108.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,901,844,556.46	19,901,844,556.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>27,072,160,501.05</u>	<u>31,561,435,538.73</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,927,540,016.38	19,963,024,602.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,383,467,051.05	6,230,457,090.16
120	Нийтлэг татварын бус орлого	319,964,628.39	481,378,578.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	319,964,628.39	481,378,578.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,545,662.67	191,438,348.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,000,000.00	65,896,657.73
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	95,418,965.72	224,043,572.91
122	Тусламжийн орлого	1,063,502,422.66	5,749,078,511.25
122001	Хандив тусламж /дотоод/	461,606,027.60	-
122002	Хандив тусламж /гадаад/	601,896,395.06	5,749,078,511.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,544,072,965.33	13,732,567,512.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,664,610,004.00	7,867,907,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,368,913,900.00	7,867,907,600.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	295,696,104.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,135,761.33	801,303,531.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,011,900.00	32,667,857.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		366,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,100,800.00	402,435,674.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69,023,061.33	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,795,327,200.00	5,063,356,381.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	4,795,327,200.00	5,063,356,381.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,547,730,200.69	15,473,935,422.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,547,730,200.69	15,473,935,422.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,534,137,050.69	15,401,239,499.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,272,932,604.71	8,544,085,579.20
210101	Үндсэн цалин	6,027,212,112.71	4,169,055,998.86
210102	Нэмэгдэл	998,281,959.00	3,678,759,402.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	95,076,000.00	319,520,639.59
210104	Урамшуулал	152,362,533.00	376,749,538.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	905,451,350.00	1,055,618,803.00
210201	Тэтгэврийн даатгал	456,943,960.00	758,287,808.00
210202	Тэтгэмжийн даатгал	230,860,028.00	63,419,326.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	59,479,208.00	64,518,655.00
210204	Ажилгүйдлийн даатгал	32,727,168.00	25,454,026.00
210205	Эрүүл мэндийн даатгал	125,440,986.00	143,938,988.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	471,032,913.12	503,487,792.96
210301	Гэрэл, цахилгаан	206,825,843.31	200,326,978.58
210302	Түлш, халаалт	156,467,976.99	146,446,148.46
210303	Цэвэр, бохир ус	107,739,092.82	156,714,665.92
2104	Хангамж, бараа материалын зардал	248,528,999.27	238,040,553.71
210401	Бичиг хэрэг	10,607,994.00	13,577,210.00
210402	Тээвэр, шатахуун	97,713,193.37	93,361,185.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,155,099.90	3,593,199.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,460,600.00	27,174,689.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,925,360.00	50,932,406.00

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210408	Бараа материал ақталсны зардал	57,666,752.00	49,401,864.06
2105	Нормативт зардал	2,591,771,409.06	2,771,825,225.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,262,150,769.06	2,416,118,254.43
210502	Хоол, хүнс	315,498,440.00	339,635,330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,122,200.00	16,071,641.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,654,500.00	85,032,308.00
210604	Урсгал засвар	73,654,500.00	85,032,308.00
2107	Томилолт, зочны зардал	7,183,200.00	6,949,070.00
210702	Дотоод албан томиллолт	7,183,200.00	6,949,070.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,455,834.93	123,628,766.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,249,182.93	37,850,954.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	2,280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,856,347.00	4,246,545.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,042,530.00	825,192.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	473,000.00	528,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,438,575.00	1,906,075.00
210807	Газрын төлбөр	6,200,000.00	36,995,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	34,996,200.00	38,996,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,878,126,239.60	2,072,571,400.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,170,100.00	480,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,872,956,139.60	2,072,091,400.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,593,150.00	72,695,922.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,198,190.00	45,157,288.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,198,190.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		45,157,288.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	27,445,705.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		27,445,705.88
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,394,960.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,394,960.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(620,190,184.31)	4,489,182,108.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(620,190,184.31)	4,489,182,108.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	11,736,464,968.00	13,989,902,518.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,987,719,202.67	257,427,935.00
120	Нийтлэг татварын бус орлого	224,545,662.67	257,427,935.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	224,545,662.67	257,335,006.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,545,662.67	191,438,348.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,000,000.00	65,896,657.73
122	Тусламжийн орлого	4,763,173,540.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	4,763,173,540.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,748,745,765.33	13,732,567,512.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,368,913,900.00	7,867,907,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,368,913,900.00	7,867,907,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	379,831,865.33	769,085,674.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,011,900.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	295,696,104.00	366,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,100,800.00	402,435,674.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69,023,061.33	450,000.00
1330	Төсвийн захирагчдаас	-	32,217,857.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		32,217,857.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	5,063,356,381.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		5,063,356,381.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	11,651,699,806.00	13,685,880,001.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,651,699,806.00	13,685,787,072.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,637,369,806.00	13,613,787,072.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,272,932,604.71	8,589,465,922.22
210101	Үндсэн цалин	4,245,197,404.71	4,678,781,451.20
210102	Нэмэгдэл	2,265,363,800.00	2,940,809,723.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	351,725,000.00	388,508,835.88
210104	Урамшуулал	410,646,400.00	581,365,911.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	905,451,350.00	1,055,618,803.00
210201	Тэтгэврийн даатгал	625,356,950.00	765,364,303.00
210202	Тэтгэмжийн даатгал	70,023,600.00	72,563,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	56,018,900.00	58,050,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,004,700.00	14,512,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	140,047,200.00	145,127,100.00

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	471,032,913.12	503,487,792.96
210301	Гэрэл, цахилгаан	194,993,867.31	200,326,978.58
210302	Түлш, халаалт	156,467,976.99	146,446,148.46
210303	Цэвэр, бохир ус	119,571,068.82	156,714,665.92
2104	Хангамж, бараа материалын зардал	184,250,603.90	201,273,305.04
210401	Бичиг хэрэг	5,292,580.00	16,056,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,401,600.00	99,201,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,622,699.90	3,622,699.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,460,600.00	31,460,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,473,124.00	50,932,406.00
2105	Нормативт зардал	2,578,439,123.17	2,978,153,910.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,205,460,683.17	2,581,872,231.40
210502	Хоол, хүнс	315,578,440.00	339,842,439.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	57,400,000.00	56,439,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	126,129,460.00	153,519,008.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,394,760.00	51,618,400.00
210602	Тавилга	8,330,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,775,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	62,629,700.00	101,600,608.00
2107	Томилолт, зочны зардал	7,183,200.00	6,949,070.00
210702	Дотоод албан томилолт	7,183,200.00	6,949,070.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,665,451.10	124,092,266.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,898,799.10	38,314,454.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	2,280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,856,347.00	4,246,545.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,042,530.00	825,192.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	473,000.00	528,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,998,575.00	1,906,075.00
210807	Газрын төлбөр	6,200,000.00	36,995,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	34,996,200.00	38,996,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,285,100.00	624,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,285,100.00	624,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,330,000.00	72,695,922.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,935,040.00	45,157,288.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,935,040.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		45,157,288.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,394,960.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,394,960.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	27,445,705.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		27,445,705.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	84,765,162.00	304,115,446.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	85,965,162.00	304,115,446.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,965,162.00	304,115,446.00
2200	Дотоод эх үүсвэрээр	85,965,162.00	304,115,446.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,965,162.00	304,115,446.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(85,965,162.00)	(304,115,446.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,200,000.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,200,000.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	-2,506,644,919.06	27,692,351,685.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	-2,506,644,919.06	27,692,351,685.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-620,191,184.31	-620,191,184.31
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	-3,126,836,103.37	27,072,160,501.05
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	-3,126,836,103.37	27,072,160,501.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	-3,126,836,103.37	27,072,160,501.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			4,489,182,108.68	4,489,182,108.68
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	1,362,346,005.31	31,561,342,609.73

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Б.Батсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 22-ны өдрийн 71 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Оношилгоо эмчилгээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 7,623,825.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 76,238.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлого 19,963,024.6 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул 1 хувиар буюу 199,630.2 мянган төгрөг болгон өөрчилсөн.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,489.1 мянган төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	23,814.00	69,194.30	45,380.30
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	770,383.90	1,233,083.20	462,699.30
Үндсэн хөрөнгө	26,277,962.50	30,259,065.10	3,981,102.60
Нийт хөрөнгө	27,072,160.50	31,561,342.60	4,489,182.10
Өр төлбөр	-	92.9	92.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,297,152.1	10,297,152.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	27,072,160.50	31,561,342.60	4,489,182.10

Авлага дансны үлдэгдэл 69,194.3 мянган төгрөг болж 45,380.3 мянган төгрөгөөр өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн татварын суутгалыг татвараас олгодог байсан нь 2021 оноос эхлэн ажил олгогч олгох болсноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2011 онд үүссэн, он удаан жил болсон 23,814.0 мянган төгрөгийн байгууллагаас /Эрүүл хүүхэд аяны татаас санхүүжилтийн/ авлага байна.

Нийт авлагаас Эрүүл хүүхэд аяны татаас санхүүжилтийн авлага барагдах боломжгүй эрсдэлтэй 23,814.0 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь найдваргүй насжилт ихтэй авлага болж төлөх эзэн хариуцагч олдохгүй болох эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,233,083.2 мянган төгрөг болж 462,699.3 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл ажил хангахтай холбоотойгоор тусгай зориулалтын бараа материал өмнөх оны эцсийн үлдэгдлээс 154,933.7 мянга, эм боох материал 287,608.8 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 30,259,065.1 мянган төгрөг болж 3,981,102.6 мянган төгрөгөөр өссөн нь 6,072,577.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 676,419.3 мянган төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгө акталж, тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардал 2,091,474.9 мянган төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрснөөс шалтгаалжээ. Үндсэн

хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 304,115.4 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5,768,462.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй харин акталсан 676,419.3 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 92.9 мянган төгрөг болж 92.9 мянган төгрөгөөр өссөн нь данс андуурсан гүйлгээ оны өмнө харилцах дансанд орсноос шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,297,152.1 мянган төгрөгт өөрчлөлт ороогүй байна.

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 7,035,484.6 мянган төгрөгөөр буюу 54.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 4,814,200.7 мянган төгрөг, урсгал санхүүжилт 1,498,993.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 421,471.7 мянган төгрөгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 1,926,204.2 мянган төгрөгөөр буюу 14.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын зардал 1,421,320.4 мянга, тогтмол зардал 32,454.8 мянга, нормативт зардал 180,053.8 мянга, урсгал засварын зардал 11,377.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 38,172.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 194,445.1 мянга, тэтгэмжийн зардал 34,959.1 мянган төгрөгийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 12,488,991.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 12,488,991.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 982,443.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 13,471,435.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлттэй нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,118,474.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол тогтмол зардлыг 201,641.7 мянга, бараа материалын зардлыг 51,483.6 мянга, нормативт зардлыг 28,753.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 7,586.0 мянга, тэтгэмжийн зардлыг 275,662.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 13,471,435.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 7,867,907.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5,307,137.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 296,390.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,867,907.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5,063,356.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 257,335.0 мянган төгрөг, нийт 13,188,599.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 13,167,041.1 мянган төгрөгийг зарцуулж 21,557.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
		1	2	3=2-1
1	Улсын төсвөөс санхүүжих	7,867,907.6	7,867,907.6	0
2	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,307,137.5	5,063,356.4	-243,781.1
3	үндсэн үйл ажиллагааны орлого	296,390.0	257,335.0	-39,055.0
4	Нийт эх үүсвэр	13,471,435.1	13,167,041.1	-282,836.1

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт төлөвлөснөөс 243,781.1 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлого 39,055.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,167,041.0 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын зардлыг 146,027.4 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 5,577.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 111,663.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 25,345.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 10,531.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 3,520.0 мянган төгрөгөөр, нийт батлагдсан төсвөөс 304,394.0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 366,200.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 369,818.9 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 32,616.8 мянган төгрөг, онцгой байдлын газраас 32,667.9 мянга, нийт 801,303.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин урамшуулал, нийгмийн даатгалын зардалд 657,845.7 мянга, бараа материалын зардалд 40,599.7 мянга, нормативт зардалд 27,443.4 мянга, урсгал засварын зардалд 32,745.3 мянга, бусад зардалд 1,699.2 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 35,082.5 мянга нийт 795,415.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,887.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 167 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 20 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,880.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 49,196.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 5,320.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,880.0	2	2,880.0	-	-	-
Албан шаардлага	2	49,196.6	2	49,196.6	-	-	-
Зөвлөмж	4	5,320.0	4	5,320.0	-	-	-
Нийт дүн	8	57,396.6	8	57,396.6	-	-	-

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 426,896.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 353,517.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 660.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 27,431.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 45,287.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгө 304,115.4 мянган төгрөгийг зардлын ангилалд оруулан тайлагнасан.
2. Бараа материалаас 49,401.9 мянган төгрөгийн акталсан бараа материалыг зарцуулснаар тайлагнасныг аудитын явцад залруулан тайлагнасан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 73,379.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 660.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 27,431.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй 2019 онд орон нутгийн болон яамны шагнал авсан ажилтнуудын шагнал урамшуулалд 660.0 мянган төгрөгийг 2020 оны төсвөөс олгосон нь Төсвийн тухай хуулийн 7.1-т “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно” заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд 4 удаа томилолтын зардлаас замын шатахуунд 1,178.4 мянган төгрөгийг жолооч, захирал нарт олгосон бөгөөд томилолтоор зарцуулах шатахууныг эхлээд шатахууны картаар хийж томилолт орсны дараа талон авч зарцуулдаг гэх боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн,

зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 26,253.4 мянган төгрөгийн хоолны материалыг “Аз лагшма” ХХК -аас худалдан авахдаа зах зээлийн үнээс өндрөөр бэлтгэсэн. Тухайлбал үхрийн махыг 11000, 10800 төгрөгөөр худалдан авч байхад бусад мах нийлүүлдэг Эрдмийт, Эрдэнэт мах маркетийн махны үнэ 8390, 8500 төгрөг, төмс 1200 төгрөг, лууван 1800 төгрөгөөр худалдан авахад хүнсний ногоо нийлүүлдэг Баясгалант Бат-Очир ХХК-ийн төмсний үнэ 900 төгрөг, лууван 1600 төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 42,287.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн худалдан авах ажиллагааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд авлага 45,380.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 69,194.3 мянган төгрөг, өглөг 92.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- 1.2. Эрсдэл: найдваргүй авлага, өр төлбөр үүсэх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заасныг хэрэгжүүлж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 269 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

2.Дотоод хяналттай холбоотой асуудал

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.1. Илрүүлэлт: Тайлант онд түрээс болон эмнэлгийн ор хоног болон үзлэгийн төлбөрт нийт 230,868.7 мянган төгрөгийг кассанд бүртгэж төрийн сангийн дансанд сард 7 удаагийн давтамжтайгаар тушаадаг байсан бол 2020 оны 11,12 сард ковид цар тахал гарснаас шалтгаалж орлого буурч сард 4 удаа тушаасан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Ашиглал, ашиг сонирхол үүсэх

2.3. Өгсөн зөвлөмж: Кассын орлогыг "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-д заасны дагуу төвлөрүүлж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 269 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:



Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

Т.БОЛОРМАА

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ОРА-2021/93/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Жилийн эцсийн санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй 2019 онд орон нутгийн болон яамны шагнал авсан ажилтнуудын шагнал урамшууллыг 2020 оны төсвөөс олгосон нь Төсвийн тухай хуулийн 7.1-т “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно” заалттай нийцэхгүй	660.0	Төлбөрийн акт	Захирал, Санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал	Б.Батсүх, Э.Баасанжаргал
2	Тайлант онд 4 удаа томилолтын зардлаас замын шатахуунд 1,178.4 мянган төгрөгийг жолооч, захирал нарт олгосон бөгөөд томилолтоор зарцуулах шатахууныг эхлээд шатахууны картаар хийж томилолт орсны дараа талон авч зарцуулдаг гэх боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	1,178.4	Албан шаардлага	Захирал, Санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал	Б.Батсүх, Э.Баасанжаргал
3	Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 26,253.4 мянган төгрөгийн хоолны материалыг Аз лагшма ХХК - аас худалдан авахдаа зах зээлийн үнээс өндрөөр бэлтгэсэн. Тухайлбал үхрийн махыг 11000, 10800 төгрөгөөр худалдан авч байхад бусад мах нийлүүлдэг Эрдмийт, Эрдэнэт мах маркетийн махны үнэ 8390, 8500 төгрөг, төмс 1200 төгрөг, лууван 1800 төгрөгөөр худалдан авахад хүнсний ногоо нийлүүлдэг Баясгалант Бат-Очир ХХК-ийн төмсний үнэ 900 төгрөг, лууван 1600 төгрөг байна.	26,253.4	Албан шаардлага	Захирал, Санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал	Б.Батсүх, Э.Баасанжаргал
4	Тайлант онд авлага 45,380.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 69,194.3 мянган төгрөг, өглөг 92.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.	45,287.4	зөвлөмж	Захирал, Санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал	Б.Батсүх, Э.Баасанжаргал

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Тайлант онд түрээс болон эмнэлгийн ор хоног болон үзлэгийн төлбөрт нийт 230,868.7 мянган төгрөгийг кассанд бүртгэж төрийн сангийн дансанд сард 7 удаагийн давтамжтайгаар тушаадаг байсан бол 2020 оны 11,12 сард ковид цар тахал гарснаас шалтгаалж орлого буурч сард 4 удаа тушаасан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь заалттай нийцэхгүй байна.	зөвлөмж	Захирал, Санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал	Б.Батсүх, Э.Баасанжаргал
ДҮН		73,379.2		

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Т.БОЛОРМАА





ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 23/23 ОРА-2021/93/СТА-ТШЗ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй 2019 онд орон нутгийн болон яамны шагнал авсан ажилтнуудын шагналд урамшуулалд 660.0 мянган төгрөгийг 2020 оны төсвөөс олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.1-т "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Өр төлбөрөөр бүртгээгүй өмнөх оны шагналд олгосон шагнал урамшууллын 660.0 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Б.Батсүх, санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал Э.Баасанжаргал нарт хариуцуулав.

¹ Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 38/2021 ОАА-ЭОМ/93/ СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 4 удаа томилолтын зардлаас замын шатахуунд 1,178.4 мянган төгрөгийг жолооч, захирал нарт олгосон бөгөөд томилолтоор зарцуулах шатахууныг эхлээд шатахууны картаар хийж томилолт орсны дараа талон авч зарцуулдаг гэх боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Томилолтын зардлаас олгосон шатахууныг хэрхэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Б.Батсүх, санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал Э.Баасанжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 39/39 ООА-2021/93/СТА-ТШЭ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 26,253.4 мянган төгрөгийн хоол, хүнсний материалыг “Аз лагшма” ХХК -аас худалдан авахдаа зах зээлийн үнээс өндрөөр бэлтгэсэн. Тухайлбал үхрийн махыг 11000, 10800 төгрөгөөр худалдан авч байхад бусад мах нийлүүлдэг Эрдмийт, Эрдэнэт мах маркетийн махны үнэ 8390, 8500 төгрөг, төмс 1200 төгрөг, лууван 1800 төгрөгөөр худалдан авахад хүнсний ногоо нийлүүлдэг Баясгалант Бат-Очир ХХК-ийн төмсний үнэ 900 төгрөг, лууван 1600 төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зах зээлийн үнээс өндөр үнээр хүнсний материал худалдан авсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн

захирал Б.Батсүх, санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал Э.Баасанжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА